

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН ҮЕЧЛЭЛИЙН АСУУДАЛД

Б.Пунсалдулам. ШУА-ийн Түүхийн хүрээлэн

Өгүүллийн товч утга: Түүхийн шинжлэх ухааны үечлэлийн асуудалд нийгмийн хөгжлийн он дарааллыг шалгуур болгон авах нь илүүтэй байдаг. Энэ шинж ч түүх бичлэгийн үечлэлд агуулагддаг. Гэхдээ түүх бичлэг нь болж өнгөрсөн үйл явдлуудын он цагийн дараалал, зураглал мэт үзэж хэт өрөөсгөл ойлгож болохгүй. Энд цаг хугацааны хүчин зүйлээс гадна эрхэмлэл, үнэлэмжийн өөрчлөлт түүх бичлэгт ямагт нөлөөлж байсныг тооцож тодруулах нь чухал юм. Монголын түүх бичлэгийн салбар ухааны хөгжлийн эхлэлийг XX зууны 20-иод оноос эхлүүлэн монголын түүх судлалын бүтээлүүдийг судалсан, судлагдхуун болгон авч үзэж буй түвшин байдлаар нь 1920-1957 он, 1957-1990 он, 1990 оноос хойшх хэмээн үечлэн авч үзлээ

Түлхүүр үг: Түүх бичлэг, үечлэл, онцлог, түвшин, судлагдхуун

Монголын түүхийн шинжлэх ухааны нэг гол салбар нь түүх бичлэгийн шинжлэх ухаан юм. Түүх бичлэгийг судлагдхуун болгон тавьснаар түүхийн шинжлэх ухааны сэтгэлгээ хөгжсөн зүй тогтол, түүхийн ерөнхий болон тусгай асуудлын судалгааны хөгжлийн тухайн шатанд ямар ахиц ололт, алдаа оноо байсныг илрүүлэн судлаж байдгийнхаа хувьд “өөрөө өөрийгөө таних” болмж олгодог бөгөөд энэ ч утгаараа түүх бичлэгийн судалгаа нь түүхийн шинжлэх ухааны хувьд түүхийн философийн асуудал болдог. Ямар асуудлыг хэрхэн судалсан буюу судалгааны түвшинд хүрсэн хийгээд судалгааны ямар арга зарчим баримтлаж байсныг илрүүлэн улмаар цаашид судалгаа шаардаж буй сэдвийг заан тодорхойлоход түүх бичлэг чухал үүрэгтэй.

Монголын түүх бичлэгийн шинжлэх ухааны түүхийг судлах үйл явц түүхийн тухай түүхийг судлахад хүргэдэг. Түүх төдийгүй түүх бичлэг өөрөө ч хувьсан өөрчлөгдөж иржээ. Үүнд өөрийн хөгжлийн зүй тогтол байна уу?, эсвэл гадны хүчний үйлчлэл илүүтэй байна уу? гэдгийг тодруулах нь бидний ярих сэдэв болоод байна. Бидний хувьд монголын түүхийн судалгаа ямар түвшинд хэрхэн судлаж, үнэлж дүгнэж байсан тухай үнэнийг хэлж чадах бөгөөд үүнийг хэлэхэд тийм ч хэцүү биш юм. Харин өнгөрсөн түүхийн талаар хийгдсэн эдгээр судалгаа зөв үү? хэмээх асуултад хариулах тийм ч амар зүйл биш юм. Учир нь энд зөв, буруу гэдгийг тогтоох шалгуурын тухай асуудал гарч ирнэ. Учир нь түүх бичигч субъектээс хамаарсан хэд хэдэн янзын алдаа гарч болох ажээ. Тэдгээрээс дурдвал: а/ “сэтгэлийн алдаа”, энэ нь ажиглаж буй субъект цаад юмандаа таатай, таагүй хандаж байгаас нь болж ажиглагдаж байгаа объектод байхгүй тийм шинж тэмдгүүдийг нь байгаа мэтээр хэлдэг, б/ “хүлцэнгүй алдаа”, энэ нь ажиглагдаж буй зүйлийнхээ өнгө төрхөд зүгээр л нийцүүлсэн үнэлгээг ажиглагчийн зүгээс өгөх явдал юм. в/ “туйлшралаас болгоомжилсон алдаа”, энэ нь судалгааны үр дүнг дундажлах гэсэн хандлагаар илэрдэг, г/ “яарсан дүгнэлт хийх алдаа”, энэ нь ердийн ухамсрын түвшин дэх явган яриа юмуу шалгагдаагүй таамналыг мэдлэг хэмээн шууд ашиглахад үндэслэдэг, д/ “мэдээллийг өөрөө л тайлбарласнаас гарах алдаа”, энэ нь ажиглагдаж буй зүйлийг “хүн хүнийхээ” байр сууринаас үнэлэх гэсэн эрмэлзлээс гардаг, е/ “харилцааны алдаа”, энэ нь ажиглагч этгээдэд өөрт нь байгаа чанар бусад хүнд бас байдагтай санал нийлэхгүйгээр маргаж мэтгэлцэхээр илэрдэг байна.¹

Энд түүхийн тухайлсан тодорхой сэдвээр судалгааны ажлыг явуулах хэрэгтэй болно. Түүхийг өөрчилж болохгүй боловч, түүнийг янз бүрээр тайлбарлаж болох билээ.

¹ Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2008, тал-11

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

Угтаа бол тухайн түүхэн үзэгдэл юмс та бидний үнэлэмжээс үл хамааран оршин ирснийг бичигч түүхэн үеийн аль нэг үйл явдал үзэгдэл, үнэлэмжтэй харьцуулан түүнийг үнэлдэг. Ингэж үнэлэх нь хэн нэгэн хүний дур зоргын асуудал биш, түүхийг объектив баримтуудад тулгуурлахыг гол шалгуур болгох ёстой. Гэвч түүхэн мэдээлэл бүхэн объектив агуулгатай байж тэр бүр чаддаггүй төдийгүй заримдаа болсон үйл явдлын зорилго, утга агуулга, үйл явцыг мушгин гуйвуулсан, тодорхой хэсэг бүлэг, хүмүүсийн эрх ашиг, үзэл бодолд нийцүүлэхийг оролдсон субъектив зохиомжтой байх тохиолдол нилээд байдаг. Ийм учраас түүх бичлэг бүхэн угтаа бодит бус харьцангуй үнэн бөгөөд тухайн түүхэн үзэгдэл юмсыг хэн нэгний үнэлэлтээс ангид авч үзвэл өөрийнхөө байгаа төрхөөр оршин байсан, оршиж буй, орших хоосон чанар юм. Өөрөөр хэлбэл бид түүхэн үйл явдал, үзэгдлийг гурван цагийн орчинд ямар нэг байдлаар бүрэн дүүрэн тодорхойлж цэг тавьж чадахгүй зөвхөн өөрсдийн хүрсэн түвшингээр л танин мэдэж болох юм. Бидний хүрсэн тухайн түвшин буюу судалгааны үр дүн болон гарч буй түүх бичлэг нь ирээдүйд хэр удаан оршин тогтнох нь түүхийг ойлгох сэтгэлгээний болон онолын арга зүйн түвшин, түүхэн тулгуур эх сурвалж баримтат тулгуурласан зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогдоно. Энд л монголын түүхийн судалгаанд ямар нэгэн гадны механик хүчний нөлөөлөл байв уу?, байсан бол хэдийн хэмжээний үйлчлэл үзүүлсэн бол?, түүний үр дагавар түүх судлалд ямар тусгал үлдээсэн бол гэх мэтээр өөрөө өөрөөсөө урган гарах олон асуудал гарч ирж байна. Тиймээс түүхийн судалгааны бүтээлүүдийг шүүн тунгаахдаа тухайн зохиогчдод нөлөөлсөн түүхэн цаг үе, нийгмийн зохион байгуулалт зэрэг хүмүүсийн үйл ажиллагаанд нөлөөлдөг олон хүчин зүйлсийн шүтэлцээнд авч үзэх хэрэгтэй болдог.

Түүхийн мэдээллийн объектив агуулгыг тодорхойлохын тулд түүнийг зохиогчийн амьдарч байсан цаг үеийн онцлог, тэр үеийн соёлын эрхэмлэл, үнэлэмжүүд, уг мэдээлэлийг хэнд зориулж хэний захиалгаар бичсэнийг, зохиогчийн өөрийнх нь хувийн үзэл бодол, нийгмийн гарвал, нийгэмд эзэлж байсан байр суурь, боловсрол зэрэг уг мэдээлэлд нөлөөлж болох субъектив хүчин зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл түүх бичлэг цаг хугацааны хүчин зүйлээс гадна эрхэмлэл, үнэлэмжийн өөрчлөлтөөс шууд хамааралтай тул тухайн мэдлэг ямагт “үнэлгээний” нөлөөлөлд байдаг бөгөөд ийм нөлөөллийг бүрмөсөн арилгах боломжгүй ч санаж байх хэрэгтэй гэсэн үг юм. Энэ нь түүхийн мэдлэгийн объектив агуулгыг үгүйсгэж түүнийг зөвхөн судлаачийн субъектив ухаарал төсөөлөл хэмээн хязгаарлаж буй хэрэг биш билээ. Энд аливаа түүхэн үйл явц бүхэн янз бүрийн хүчин зүйлсийн зохирол бүрдсэн зангилаа байдгийг ямагт санах ёстойг онцлон тэмдэглэж байна. Түүх бичлэгт түүхэн цаг хугацаа, нийгэм, ухамсар болон гадны хүчин зүйлсийн нөлөөлөл хэр байсныг гарган тодруулах, үнэлэлт дүгнэлт өгөх, шинийг эрж хайхдаа зөвхөн өнөөгийн оюун санааны түвшингээр хандаж, өмнө байсан зүйлийг буруутгахын тулд л буруутгаж буй хэрэг биш гэдгийг цаг ямагт мартахгүйгээр санах ёстой. Энэ нь өмнөх үеийн үнэт зүйл, зорилго, утга агуулга өөрчлөгдсөнтэй холбоотой өмнөх үеийн түүхийн судалгааг дахин үнэлэх явдал болохоос түүхийн бодит байдалд өөрчлөлт гарсан гэсэн үг биш билээ. Нөгөөтэйгүүр тухайн түвшинд хийсэн судалгаа, үнэлэмж, дүгнэлтүүд төгс дахин боловсруулагдахгүй гэсэн үг биш. Бидний хувьд монголын түүхийн судалгааны бүтээлүүдийг судлагдхуун болгон тавьж судлахыг зорьсонгүй. Харин монгол улсын түүх бичлэгийн ухааны өөрийнх нь түүхийн хөгжлийн ерөнхий динамик зүй тогтол, түвшинг тодруулах зорилго агуулж буй билээ. Монголчуудын түүхээ бичиж тэмдэглэж ирсэн түүхийн сэтгэлгээний арга зүй хэрхэн өөрчлөгдлөн уламжлагдан ирснийг тодруулах зорилтыг агуулж байна. Аль ч үеийн нийгмийн томоохон өөрчлөлтүүд үзэл санаа, ертөнцийг үзэх үзлийн тодорхой хөрсөнд үндэслэн үүсэж бэхжиж иржээ.

Монголын түүх бичлэгийн үүсэл хөгжлийн асуудлыг тодруулахын тулд түүний хөгжлийн үе шат, шат бүрийн онцлог шинж, хэлбэр, уламжлалыг тодруулах нь арга зүйн хувьд хөтлөх гарц хэмээн бодож байна. Учир нь түүх бичлэгийн хөгжлийг үечлэн авч үзэх нь түүний хөгжлийн мөн чанарыг нарийвчилсан тодорхой хэсэг үеүдэд хувааж, дотоод гол

шинж учир шалтгааныг танин мэдэж, түүгээрээ дамжуулан Монголын түүх бичлэгийн ухааны үүсэл хөгжлийн динамикийг тодруулна. Үүний тулд Монголын түүх бичлэгийн хөгжлийн үе шат, түүний хөгжлийг үечлэх ангилахдаа чухам юуг үндэс болгож буйгаа тодорхойлох нь зүйн хэрэг юм.

Түүхийн шинжлэх ухааны үечлэлд нийгмийн хөгжлийн он дарааллыг шалгуур болгон авах нь илүүтэй байдаг. Энэ шинж ч түүх бичлэгийн үечлэлд агуулагддаг. Гэхдээ түүх бичлэг нь болж өнгөрсөн үйл явдлуудын он цагийн дараалал, зураглал мэт үзэж хэт өрөөсгөл ойлгож болохгүй. Энд цаг хугацааны хүчин зүйлээс гадна эрхэмлэл, үнэлэмжийн өөрчлөлт түүх бичлэгт ямагт нөлөөлж байсныг тооцож тодруулах нь чухал юм. Өөрөөр хэлбэл түүх бичлэгийг үечлэх зохих шалгуур нь объектив, субъектив хоёр хүчин зүйлээс хамааралтай бөгөөд үүгээрээ түүхээс ялгагддаг билээ.

Түүх бичлэгийг зөвхөн бичмэл хэлбэрээр хүлээн авах нь явцуу хүрээнд оруулна. Түүх бичлэг нь түүхэн үзэгдэл юм. Тиймээс түүх бичлэг бүхэн тухайн цаг үеийн агуулга, шинж төрхийг өөртөө агуулснаар түүхэн объектив тал шинжийг, тухайн нийгмийн оюун санааны тусгал хэмээх утгаараа субъектив шинжийг агуулдаг хоёрдмол шинжээрээ “түүх” хэмээх ухагдхуунаас ялгагддаг. Түүх бичлэгийн мэдээллийн объектив агуулга гэдэгт түүнийг зохиогчийн амьдарч байсан цаг үеийн онцлог, гадаад, дотоод түүхэн тодорхой нөхцөл, тэр үеийн соёлын эрхэмлэл, үнэлэмжүүд зэрэг түүх бичлэгт зайлшгүй нөлөөлөх хүчин зүйлсийг хамруулан үзэж байна. Харин субъектив хүчин зүйлст зохиогчийн / бүтээгчийн/ өөрийнх нь хувийн үзэл бодол, нийгмийн гарвал, нийгэмд эзэлж байсан байр суурь, гүйцэтгэх үүрэг гэх мэт уг мэдээлэлд нөлөөлж буй талуудыг хамруулан үзэж байна. Гэхдээ түүх бичлэгийн субъектив тал шинж ч өөртөө объектив, субъектив талыг агуулгийг тэмдэглэх хэрэгтэй. Тиймээс ч бид түүхийг судлахдаа дээрх шинж талыг үндэслэн түүхийн судалгааны “эх сурвалж”, “баримт” гэх ухагдхууныг гарган ирсэн билээ. Бидний тэрхүү сурвалж хэмээн үзэж буй гол үндэслэл нь тухайн түүх бичлэгийн эмпирик шинж чанарыг үнэлж буй хэрэг юм. Тэгэхээр өнгөрсөн үеэс бидэнд үлдсэн түүх бичлэгийг судлагдхуун болгон тавихдаа тэрхүү мэдээллүүдийн жинэхэнэ утга чанар юу болох, тухайн мэдээ шууд утгатай юу?, эсвэл далд утгатай юу? гэдгийг таниж мэдэх, тайлбарлах олон янзын арга, мөн зорилго, үр дүн байх нь гарцаагүй юм.

Эрт эдүгээгийн түүхийн тухай мэдээлэл бидэнд түүх бичлэгийн олон хэлбэрээр (чулуун багаж зэвсэг, бууц суурин, хадны зураг, булш хиргисүүр, буган хөшөө, цуглавар олдвор, үлгэр, тууль, домог гэх мэт- Б.П) үлдэж иржээ. Хэрэв түүхийн тусгал болсон энэхүү түүх бичлэгийн олон хэлбэр үлдэж хоцроогүй бол бид үүх түүхээ судлан өнөөгийн зорилтоо тодруулан, хөгжлийн цаашдын чиг хандлагын тухай ярих нь тодорхойгүй болж хувирна.

Монголын түүх бичлэгийн үүсэл хөгжил монгол газар монголчуудын түүхээ бүтээсэн тэр цаг үеэс эхтэй төдийгүй нягт холбоотой хөгжиж ирсэн түүхэн үзэгдэл юм. Харин түүх бичлэг Монголын түүхийн шинжлэх ухааны салбар ухаан болон хөгжиж ирсэн үйл явц нилээд хожуу буюу XX зуунд холбогдоно.

XX зуунд Монголын уламжлалт түүх судлалд суурилсан түүхийн шинжлэх ухаан жинэхэнэ утгаараа бүрэлдэн төлөвшсөн билээ. Түүхийг хаадын түүх, шашин дэлгэрсэн түүх төдийгөөр хязгаарлах хуучны төсөөлөл, бичлэгийн арга барилаас татгалзаж шинжлэх ухааны үүднээс ойлгож, уламжлалт түүхээ хянан эргэцүүлж, шинэчлэх санаачлага идэвхжиж, түүхийн мэдлэгийн агуулга, арга зүй, шинж чанарт том өөрчлөлт гарсан юм. Хөгжлийн 120 гаран жилд Монголын түүхийн шинжлэх ухаан бэрхшээл саадыг даван туулж цаг үеийг сөрөн зогсож эх түүхээ уламжлуулан хөгжүүлж ирсэн юм. Хөгжлийн энэ хугацаанд түүхийн судалгаа нэг хэв загварын байдалд орж “хар”, “цагаан” толбо бий болж зогсонги байдалд орсон хэдий ч түүх судлалд шинэчлэл хийх, дахин шинээр харах, үнэлэх зэргээр түүхийг үзэх үзэлд чанарын өөрчлөлт гарч хөгжин дэвшиж иржээ. Бидний хуруугаараа чичих дуртай марксист түүх бичлэгийн үед монголын

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

түүхийн шинжлэх ухаан хөгжлийнхөө урагш давших чухал алхамаа хийснийг онцлон тэмдэглэж байна.

Монголын түүх бичлэгийн хөгжлийн үечлэлийг анх Х.Пэрлээ “Монголын хувьсгалын өмнөх түүх бичлэгийн асуудалд” хэмээх даацтай бэсрэг бүтээлдээ 1921 оны өмнөх 700-гаад жилийн монголынчуудын түүх бичлэгийн хөгжлийг Нэг. Бичлэгийн хэлбэр, асгуулгаар нь 1. Дан төрийн түүх, 2. Дан шажны түүхийг холилдуулан бичсэн, 3. Монголд шашин дэлгэрнийг бичсэн, 4. Түүх-төрийн намтрыг холилдуулан бичсэн хэмээн дөрөв ангиласан бөгөөд, Хоёрт. Монголын түүхийн хөгжлийн үе шатыг шалгуур болгон 1. Монгол нутагт байсан эртний улсуудын үеийн түүхийн мэдлэг (VIII-XII), 2. Монгол гүрний үеийн түүхийн мэдлэг (XIII-XIV), 3. Монголын феодалын бутралын үеийн түүхийн мэдлэг (XV-XVII), 4. Манжийн дарлалд байсан үеийн түүхийн мэдлэг (XVII-XIX), 5. Монголын шашин төрийг хослон баригч хаани улсын үеийн түүхийн мэдлэг (1911-1920 он) хэмээн хуваагаад, Гуравт. Монголчуудын түүхийн мэдлэгийг хөгжлийн явц түвшин хурдцаар нь 1. хөгжсөн (XIII-XIV зуун), 2. саарсан (XV-XVI зуун), 3. сэргэсэн (XVII-XIX зуун) хэмээн хувааж болох тухайд саналаа дэвшүүлсэн байдаг.²

Монголчуудын түүхийн мэдлэг ухааны хөгжлийг нилээд тулхтай судалсан түүхч, академич Ш.Бира “Монголын түүх бичлэг (XIII-XVII зуун) бүтээлдээ монголчуудын түүхийн мэдлэгийн хөгжлийн явцыг түүхийн хөгжлийн үе шатны дагуу дөрвөн үед хуваажээ. Үүнд: 1. Эртнээс аваад феодализм батжиж байсан үе хүртэлх түүхий мэдлэг (эртнээс-XIV зууны үе хүртэл), 2. Хөгжингүй феодализм ба феодалын бутралын үе (XIII-XVII зуун), 3. Манжийн ноёрхол тогтож феодализм ялзран доройтсон үе (XVII-XX зуун), 4. Марксист ленинист түүх бичлэг үүсэн хөгжсөн үе (1921-1970) хэмээн үечилжээ³.

Ардын хувьсгалаас хойшхи монголын түүх бичлэгийг түүхч Ц.Ишдорж, Д.Батбаяр нар “БНМАУ түүхийн шинжлэх ухаан 60 жилд” өгүүлэлдээ монгол орны орчин үеийн хөгжлийн үе шатанд тулгуурлан 1. Монголын түүх бичлэгийн хувьсгалт ардчилсан шат (1921-1940), 2. Марксист ленинист шат (1940 оноос хойш) хэмээн хувааж, үе тус бүрийн түүхийн судалгааны бүтээлүүдийг тоймлон харуулсан байна⁴.

Түүхч Н.Хишигт “Отечественная историография истории Монгольской Народной революции” өгүүлэлдээ 1921 оны ардын хувьсгалын түүхээр гарсан бүтээлүүдийг түүх бичлэгийн хэлбэр, агуулга, арга зүй зэрэг өөрийнх нь үндсэн шинж чанарт түшиглэн дараах үед хуваасан байна. 1. 1921-1934 оны үеийн түүх бичлэг, 2. 1935-1954 оны үеийн түүх бичлэг, 3. 1955 оноос одоог хүртэлх үеийн түүх бичлэг гэсэн үед хуваан, үе тус бүрийн онцлог, шинжийг тодорхойлон өөрийн үнэлэлт дүгнэлтийг өгчээ⁵.

XX зууны Монголын түүхт хүмүүсийн намтарын түүх бичлэгийн хөгжлийг түүхч З.Лонжид хугацаа агуулгаар нь 1921-1928, 1929-1940, 1941-1945, 1946-1988, 1990 оноос хойш хэмээн үечлэн авч үзсэн байна⁶. Энд дурдагдаж буй үечлэлүүд нь тухайлсан сэдвээр судалгааны ажил хийсэн эрдэмтэн судлаачдын санал юм. Учир нь судлаачид түүх бичлэгийн мэдээллийн обьектив агуулга, түүнийг зохиогчийн амьдарч байсан цаг үеийн онцлог, гадаад дотоод түүхэн тодорхой нөхцөл, тэр үеийн соёлын эрхэмлэл, үнэлэмжүүд, уг мэдээлэл хэнд зориулж бичсэн зэрэг түүхч билэгт зайлшгүй нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан саналаа дэвшүүлэн тавьжээ. Х.Пэрлээ, Ш.Бира, Ц.Ишдорж, Д.Батбаяр нар Монголчуудын түүхийн бичлэгийг түүхэн хөгжлийн ерөнхий цар хүрээнд тогтон үечилсэн бол Н.Хишигт, З.Лонжид нар тухайлсан сэдвээр түүхийн судалгааны бүтээлүүдийг судлагдхуун болгон тавьж үечилжээ.

Монголын түүх бичлэгийн салбар ухааны хөгжлийн эхлэлийг XX зууны 20-иод оноос эхлүүлэн монголын түүх судлалын бүтээлүүдийг судалсан буюу судлагдхуун

² Дурдсан зохиол, т-4

³ Ш.Бира Монголын түүх бичлэг (XIII-XVII зуун) УБ., 1972, т-4.

⁴ Түүх судлал. XVII боть. УБ., 1983, т-19

⁵ Түүхийн судлал. XXI боть. УБ., 1987, т-23

⁶ XX зууны Монголын түүхийн асуудлууд. Эмхтгэл. УБ., 1999

болгосон түвшин байдлаар нь 1920-1957 он, 1957-1990 он, 1990 оноос хойшх хэмээн тоймлон үзлээ. Түүх бичлэг түүхийн шинжлэх ухааны салбар ухаан болон хөгжсөн эхлэлийг урагшлуулан XX зууны 20-иод оноос эхлүүлж буй үндэслэлээ юуны өмнө түүхийн шинжлэх ухааны хөгжлийн явцтай холбон үзэж буй юм. Үүнд: I-д. Монголд эх түүхийн судалгаа, түүхийн шинжлэх ухаан хөгжихийн хэрээр түүх бичлэгийн судалгаа ч тодорхой хэмжээнд хамт хөгжсөөр ирсэн. Өгүүлэн буй үед Монголын түүх бичлэгийн ухааны судалгаа тойм, шүүмж, сурталчилгааны түвшинд явагдаж байв. Түүх судлал тодорхой амжилтанд хүрэхийн хамт хөгжлийн эхний үед судлаачид чухам хийснээ эргэн харах тооцох, цаашид юу хийхээ тодруулахын тулд Монголын түүх судлалын төлөв байдлыг ерөнхийлэн харж, зорилгоо тодруулж байв. Өөрөөр хэлбэл манай түүх судлаачид одоо юу хийгээд байгаа, цаашид юунд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй буйгаа тодруулсан олон арван өгүүллийг тухайн үеийнхээ сэтгүүл сонин дээр нийтлүүлж байв. Шинжлэх ухааны хүрээлэнгийн Түүхийн тасгаас явуулсан ажлаа нэгтгэн дүгнэж цаашид юунд анхаарал хандуулах хэрэгтэй байгаагаа тодруулсан А.Амар “Арван жилийн ой ба шинжлэх ухааны үйлдвэр” /УБ., 1931.МУХХ. 133 тал, хуучин үсгээр/ хэмээх товхим, мөн 1935 оны дундуур шинээр байгуулагдсан түүхийн тасгийн эрхлэгчээр томилогдсон Д.Нацагдоржийн боловсруулан “Эх түүхийн тасгийн зорилго”, “Түүхийн тасгийн үндсэн дор гүйцэтгэх ажил” хэмээх хоёр зүйлийн баримт бичгийг дурдах нь зүйтэй. Үүний хамт түүхч Ш.Нацагдорж, Н.Ишжамц, Х.Пэрлээ, Ц.Доржсүрэн нарын монголын эх түүхийн судалгааны хүрээнд хийсэн ажил, цаашид хийх зорилтын талаар өгүүлсэн сурталчилгаа, мэдээллийн чанартай өгүүлүүд хэвлэгдэн гарсан байна. Тухайлбал, түүхч Ш.Нацагдорж 1941 оны “Шинжлэх ухаан” сэтгүүлийн №3-т “Шинжлэх ухааны хүрээлэнгээс түүхийн талаар явуулсан ажил”, “Хуучны дурсгалт зүйлийг сахин хамгаалах нь ямар учраас чухал вэ?”, 1942 онд намын байгуулалтын сэтгүүлийн №9-д “Түүх судлалыг дээд шатанд гаргая”, 1946 онд “Шинжлэх ухаан” сэтгүүлийн № 12-13-т “Шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхийн кабинетийн ажил”, 1949 оны “Шинжлэх ухаан” сэтгүүлийн №16-19-т “БНМАУ-ын түүхийг зохиож байна”, 1951 онд “Шинжлэх ухаан” сэтгүүлийн №3-т “Түүх судлалын талаар гүйцэтгэсэн ажил”, 1956 онд “Үнэн” сонины №216-д Түүхчдийн ажлыг өөрчлөн зохиоё”, мөн онд түүхч Н.Ишжамцын хамт “БНМАУ дахь түүхийн шинжлэх ухаан” өгүүллийг орос хэлээр “Советское востоковедение” /1956.№2/-т, Ц.Доржсүрэн “Манай орон эрт цагт” /ШУТ, 1958.№3/, Х.Пэрлээ “1951-1953 онд явуулсан археологийн шинжилгээний тухай товч мэдээ” /ШУ.1954.№2/, “Монголын археологийн тухай” ОУМС, 1963.№8/, “Ц.Доржсүрэн “БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсгийн судлаачийн байдал” /УБ., 1957/, Н.Сэр-Оджав “БНМАУ-д явуулсан археологийн ажлын тухай. /ШУТ.1958.№2/ зэрэг олон арван сурталчилгаа, нийтлэлийн өгүүлүүд гарч судалгаа шинжилгээний ажлын үр дүн, зорилго чиглэлээ тодруулж байжээ. Мөн Монголын түүхийн тасгаас урьд хэвлэгдсэн өгүүлэл, номонд шүүмж бичих тусгай төлөвлөгөө гарган судалгааны бүтээлүүдийн чанарт онцгой анхаарал тавин ажиллаж байв. 1941 оны Хүрээлэнгийн жилийн ажлын тайлан дотор “Нацагдорж, Цэвэл нарын “Нууц товчооны оршилын тухай” статьяны тухай Дамдинсүрэн, Монголчуудын цэргийн чадвар хэмээсэн 1942 оны Шинжлэх ухаан сэтгүүлд гарсан Пэрэнлэйн статьяны тухай Пунцагноров, “Монголын эртний соёл” хэмээсэн 1944 оны Шинжлэх ухаан сэтгүүлд гарсан Пэрэнлэйн статьяны тухай Төртогтох, “Манлайбаатар Дамдинсүрэн” хэмээсэн Нацагдоржийн зохиолын тухай Цэдэн, “Чингисийн дараах хаадын үеийн Монгол гүрэн” хэмээх Нацагдоржийн зохиолын тухай Түдэв, “Зоригт баатар Тогтох” хэмээсэн Навааннамжилын зохиолын тухай Цэдэн, “Халх дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний тухай” Нацагдоржийн зохиолын тухай Пунцагноров нар уншиж шалган шүүмж бичнэ хэмээн төлөвлөсөн байна. Ийнхүү судлаачид өөрсдийнхөө өгүүллийг нягтлан уншиж чухам ямар асуудлыг хэрхэн судалж буй, ямар амжилт олсон, цаашид юунд анхаарыг зөвлөсөн шүүмж бичиж буй нь түүхийн шинжлэх ухааны хөгжлийн түвшинг тодорхойлох үүрэг бүхий түүх бичлэгийн салбар ухаан хамт хөгжиж буйг гэрчлэнэ.

2-т. Монголын “чулуун” түүх бичлэгийг судлагдхуун болгон тавих анхны археологи хайгуул шинжилгээний ажил 1922 оноос Оросын Шинжлэх ухааны академитай хамтран хөшөө булш, хуучин хот, хэрмийг шинээр олж малтах, судлагдхуун болгох судалгааны ажлыг эхлүүлсэн байна. Цаашид археологийн шинжлэх ухаан болон бие даан хөгжиж, өдгөө эрдэмтэн судлаачдын бүтээлээр түүх бичлэгийн судалгааг явуулах хэмжээнд хүртлээ өсөн дэвшжээ.

Өгүүлэн буй үед мэргэжлийн үндэсний боловсон хүчин хараахан төрж амжаагүй байсан учир түүх судлалын салбарт гол төлөв ардын засгийн хэрэгт хүчин зүтгэж байсан үндэсний дэвшилт ардчилсан үзэлтэй хуучин түүхчид, бичгийн хүмүүс уламжлалт ёсыг баримтлан ард түмнийхээ түүхийг судлан боловсруулах ажил хийж байв. Монголын түүх судлалд үндэсний дэвшилт ардчилсан үзэлтэй ахмад түүхчид, бичгийн хүмүүс, эрдэмт лам нараас гадна, нам, төрийн зүтгэлтнүүд ард түмнийхээ түүхийг судлан боловсруулах ажилд зохих хувь нэмэрээ оруулж байв. Тухайлбал А.Амар (Ерөнхий сайдын ажлыг хашиж байв), Н.Магсаржав (Ардын засгийн шүүх яамны анхны тэргүүн сайд), Х.Чойбалсан (бүх цэргийн жанжин /1924.08.27/, намын төв хорооны тэргүүлэгч /1924.08 сараас/), Д.Лосол (намын төв хорооны тэргүүлэгч /1921.03-1928.08/, Ардын засгийн газрын сангийн яамны дарга /1921.04-07сар/, Хянан байцаах яамны сайд /1925-1926 он/), Г.Дэмид (бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч /1930.04.27-1932.07/, намын төв хорооны тэргүүлэгч /1930.03-1937.10/) нарыг дурдаж болох юм. Ахмад түүхчид эх түүхээ уламжлалт ёсыг баримтлан, эмперик түвшинд буюу тухайн үеийнхээ оюун санааны түвшин, үнэлэмжээр өөрийн үзсэн харсан дуулснаа энгийн хэллэгээр, дурсамж дуртгалын хэлбэрээр болсон үйл явдлыг хураангуйлан өгүүлсэн байдаг. Өөрөөр хэлбэл энэ түвшингийн түүх бичлэгт ямар нэг анги, намын эрх ашгийг илэрхийлээгүй учраас зарим талаар эх сурвалжийн шинжийг өөртөө агуулж байдгаараа онцлог юм.

Монголын түүх бичлэгийн хөгжлийн хоёрдугаар үеийг 1950-иад оны сүүл үеэс эхлүүлэн авч үзэж байна. Үүнд: 1. Түүх судалдаг байгууллага, түүхийн судалгаа явуулах үндэсний боловсон хүчин түүхч судлаачид гадаадад төдийгүй дотоод бэлтгэгдэн монголын түүхийн тухайлсан сэдвээр суурь судалгааны ажил явуулж олон арван эрдэм судлалын өгүүллүүд, нэгэн сэдэвт зохиол бүтээл хэвлэгдэн гарсан, түүхийн судалгааны арга зүйд марксист онол арга зүй төлөвшин тогтсон зэрэг үндсэн шинжийг юуны өмнө тодруулан өгүүлж байна.

Монголын түүхийн судалгааг эрхлэн явуулдаг хүрээлэн, төвүүд 1950-иад оноос эхлэн байгуулагдсанаар монголын түүхийн шинжлэх ухааны хөгжилд чухал хувь нэмэр оруулах болжээ. Үүнд: МАХН-ын төв хорооны харъяанд Намын түүхийн хүрээлэн, 1959 онд БХЯ-ны Улс төрийн газрын харъяа Цэргийн түүхийн тасаг, Ардын боловсролын яамны харъяа Боловсрол судлалын хүрээлэн тус тус байгуулагджээ. Мөн их дээд сургуулийн түүх, нийгмийн ухааны тэнхимүүд байгуулагдаж, монголын түүхийн сургалт, судалгааг явуулах болсон юм. Бидний ангилалын марксист түүх бичлэгийн үед Монголд түүхийн судалгаа, сургалтыг эрхлэн явуулах байгууллага:

Монголын түүхийн судалгааны ажлыг эрхлэн явуулах төв байгууллага нь Түүхийн хүрээлэн юм. 1961 онд Шинжлэх Ухааны Академи байгуулагдаж, түүний бүрэлдэхүүнд Түүхийн хүрээлэнг байгуулснаар Монголын түүхийн бүхий л үеэрх судалгааны ажил өргөжиж гадаад дотоодод эрдмийн зэрэг хамгаалсан үндэсний боловсон хүчнээр бэхжсэн байна. Монголын түүхийн чиглэлээр судалгаа явуулдаг бусад хүрээлэн, төвүүд орно Үүнд Дорно дахины судлалын хүрээлэн, Намын түүхийн институт, Улсын түүхийн архив, Боловсрол судлалын хүрээлэн, БХЯ-ны харъяа Цэргийн түүхийн тасгаас монголын түүхийг судлан боловсруулж байв. Энэ үеэс түүх судлалын материаллаг бааз бэхжин Үндэсний түүхийн төв архив, МАХН-ын түүхийн архивуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй эмхлэн зохион байгуулагдснаар монголын түүхийн холбогдолтой архивын баримт бичгийн эмхтгэлүүд, сурвалж бичгүүд хэвлэгдэн гарах болсон нь монголын түүхийн судалгааны цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмрийг оруулжээ.

Их дээд сургуулийн монголын түүхийн тэнхмүүд / МУИС, УБДС, ХААДС/ гэсэн бүтэцтэй байв. Монголд үндэсний түүхч мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдэн гарах болжээ. Тухайлбал 1947 онд МУИС-д түүхийн салбарыг нээж анхны оюутан элсүүлж авснаас хойш өдгөө 48 дахь төгсөлтөө хийж үндэсний дээд боловсролтой 1300 гаруй түүхч мэргэжилтэн бэлтгэсэн байна. МУИС-ийн түүхийн ангийн оюутнуудад “Монголчуудын түүх бичлэгийн түүх” хэмээх хичээлийг 1970 оноос оноос эхлэн тусгайлан заах болсон бөгөөд энэ хичээлийг заасан анхны багш нь судлаач Х.Пэрлээ байжээ⁷.

Түүх судлалын байгууллага хүрээлэн, төв, архивын байгууллага жинхэнэ ёсоор хөгжсөн нь түүхийн судалгааны хэвлэлийн баазын өсөлтөд нөлөөсөн байна. 1960-аад оноос “Түүх судлал”, “Археологи судлал”, “Этнографийн судлал”, “МАХН-ын түүхийн судлал”, 1978 оноос “Дорно дахины судлалын асуудал”, 1979 оноос “БНМАУ- дахь нийгмийн ухаан” гэдэг цуврал бичиг гарах болжээ. Бичгийн судар ном бүтээлийг тухайлан судлах зорилт тавьсан түүхийн хүрээлэнгийн үйл ажиллагаатай холбон авч үзэж байна. 1959 оноос Түүхийн хүрээлэнгээс эрхлэн “Studia historica” түүхийн цуврал, “Studia ethnographica” /угсаатны зүйн цуврал/ “Studia archeologica” /археологийн цуврал/, “Monumenta historica” /сурвалж бичгийн сурвалж/ хэмээх дөрвөн сэтгүүлийг хэвлэн нийтлэж “Studia historica”-ийн анхны дугаараас эхлэн монголын түүх бичлэг, сурвалж судлалын холбогдолтой өгүүллүүд хэвлэгдэх болсон байна. Анхны дугаарт “Монгол улсын Автономи гэдэг өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал, чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл гэдэг түүх бичиг” хэмээх XX эхэн үеийн түүхэнд холбогдох сурвалжийг нийтлэн эрдэм шинжилгээний эргэлтэд оруулжээ.

“Studia historica” түүхийн цувралын хоёр дахь хэвлэл монголын түүхийн судалгааны тойм, түүх бичлэгт тусгайлан зориулагдажээ. Энэхүү цувралд Д.Цэдэв “Монголын түүх бичлэг 40 жилд”, Ш.Бира.Монголын түүхэнд Гунгаадоржийн “Улаан дэвтэр”-ийн холбогдох нь”, Б.Түдэв. БНМАУ-ын ажилчин ангийн түүхийг судлаж байгаа байдлаас”, Д.Доржийн “Монгол орны хад чулууны дээрх зураг сүгийн зүйлд” хэмээх өгүүллүүд нийтлэгдсэн байна⁸.

“Studia archeologia” цувралын хоёр дугаарт Н.Сэр-Оджавын “40 жилд БНМАУ-д хийсэн эртний судлалын шинжилгээ”⁹ өгүүлэл нийтлэгдсэн бөгөөд дараа дараагийн цувралд тухайн жилд хийсэн археологийн ажлын тайланг өгүүлсэн олон арван өгүүлэл нийтлэгджээ. “Monumenta hustrica” сэтгүүл 1961 оноос эхлэн гарсан бөгөөд анхны хэвлэл нь Sagan-secen. Erdeni-un Tobci нэртэйгээр хэвлэгдэн гарчээ¹⁰.

Бидний ангилалын хоёр дахь үеэс түүхийн түүх судлал буюу түүх бичлэг, сурвалж судлалаар тусгайлан эрдэм судлалын ажлыг явуулах боломж түвшин Монголд нэгэнт бүрэлдэн тогтож судлаачид түүх бичлэг, сурвалж судлалын тухайлсан асуудлаар эрдмийн зэрэг цол хамгаалсан диссертаци, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих болсон нь Монголын түүх бичлэгийн салбар ухааны хөгжлийг урагш ахиулах том алхам болжээ. Үүнд: түүхч Х.Пэрлээгийн “Монголын хувьсгалын өмнөх түүх бичлэгийн асуудалд” /УБ.,1958/, М.Санждорж “Монголын феодалын түүх бичлэг” /“Багш” сэтгүүл.УБ., 1958. №3, т.15-20/, Ш.Бирагийн “Опыт историографического исследования “Сэрги дептэра” Дамдина /К вопросу об изучении монгольской тибетскоязычной исторической литературы/ түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээл, өгүүллүүдийг нэрлэж болно.

1962 онд Л.Жамсран БНХАУ-д “Цю Цю Сы дунд гурван хилийн Монгол ван тайж нарын намтар (Ваньлингийн цэргийн гавьяаны тэмдэглэлийн 7,8,9-р бүлгүүд) сэдвээр түүхийн ухааны

⁷ Х.Пэрлээ. Эртний Монголчуудын нүүдэлч соёл иргэншлийн түүхийн зарим асуудал /докторын зэрэг горилогчийн холбогдох материал/ ШУА-ийн Түүхийн хүрээлэн. Түүхийн баримтын сан. Ф-6,ХН.118, т-86

⁸ /Монголын түүх, эртний судлал, угсаатны зүйн зарим асуудал. ШН. Т.П. УБ.,1962/.

⁹ Эртний судлал. Угсаатны зүйн бүтээл. Эрхэлсэн Н.Сэр-Оджав. ШУАХ.УБ.,1963.

¹⁰ Sagan-secen. Erdeni-un Tobci. Хэвлэлд бэлтгэсэн Ц.Насанбалжир. УБ.,1961.

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

докторын зэрэг горилсон диссертацийг бичиж Бээжин хотноо ¹¹, 1989 онд Ж.Баясах “Записки южносунских дипломатов как историко-этнографический источник по истории и этнографии Монголы XIII века” сэдвээр диссертаци бичиж хамгаалсан нь монголын сурвалж судлалын салбар төдийгүй түүх бичлэгийн судалгаанд шинэлэг талыг авчирсан байна. Үүнээс гадна Монголын уламжлалт түүх бичлэгийн бүтээлүүдийн хөрвүүлэг болон тайлбарласан өгүүлэл, товхимолыг хэвлүүлэх болжээ. Х.Пэрлээ “Урьд мэдэгдээгүй гурван бичмэл”/1957/, “Монголын хувьсгалын өмнөх түүх бичлэгийн асуудал”/1957, “Дөчин дөрвөн хоёрын их цааз”/Хөрвүүл.1959/, “Дондогдаш хааны үеийн Ижил мөрний халимагуудын зохиосон шашин төрийн зарчим” /Хөрвүүлэг.1959/, Галдан хун тайжийн захиа зарлиг /Хөрвүүлэг 1959/, “Шар туужийн зохиогчийн тухай” /1970/ “Монголын түүхийн тухай тэмдэглэлүүд”. /1971/, “Халхын шинэ олдсон хууль эрхэмжийн дурсгалт бичиг”/1973/ ¹², Ш.Нацагдорж Алтан товчийн зохиогчийн тухай /1958/, “Халхын Цогт хунтайжийн холбогдолтой нэгэн сурвалж бичгийн тухай”, Улаан хацарт /1960/, Дөрвөн амйгийн алба тэгштгэсэн данс (Ц.Насанбалжирын хамт) /1962/, Ардын заргын бичиг. (Ц.Насанбалжирын хамт) /1968/, Харьяат хошууны дотор дагаж явуулахаар тогтоон тушаасан ухуулах бичгийн эх. /1960/ ¹³, Ш.Бира Анализ основных данных “Белой истории” и время ее составления /1970/, “Хутугтай цэцэн хун тайжийн зохиосон нэгэн хуулийн тухай”, “XVI зууны нэгэн Монгол цаазны бичиг” ¹⁴ зэргийг дурьдаж болно. Энэ бүхэн түүх бичлэгийн ухааны хөгжилд үнэтэй хувь нэмрийг оруулжээ.

1986 онд Н.Алтанцэцэг “Освещение истории антиманьчурской национально-освободительной борьбы монгольского народа в историографии КНР” сэдвээр диссертаци бичиж БНХАУ-ын түүхч судлаачдын бүтээлүүдийг судлагдхуун болгон тавьж түүнд монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг хэрхэн үнэлж дүгнэж буйг гарган үзүүлснээрээ монголын түүх бичлэгийн ухаан өөрийн хөгжлийн тодорхой түвшинд хүрснийг илтгэн харуулж байна. Мөн онд Ц.Ишдорж “Зарождение и становление современной монгольской историографии 1921-1940гг” сэдвээр, 1989 онд Д. Батбаяр “Современная историография руководства МНРП переходном народно-Монголии к социализму, минуя капитализм /с учетом опыта КПСС/”, сэдвээр тус тус хамгаалжээ ¹⁵. Дээрх бүтээлүүд нь монголын түүхчдийн бүтээлүүдийг марксист-ленинист онол арга зүйн үүднээс задлан шинжилж, монголын түүхчдийн судалгааны бүтээлүүдийг судлагдхуун болгон тавьж Монголын түүх бичлэгийн ухааны хөгжлийг нэгд, хувьсгалт ардчилсан шат (1921-1940-өөд он), хоёрт, марксист –ленинист шат (1940-1985) хэмээх үндсэн хоёр үед

¹¹ Л.Жамсран. Цю Цю Сы дунд гжрван хилийн Монгол ван тайж нарын намтар (Ваньлингийн цэргийн гавъяаны тэмдэглэлийн 7,8,9-р бүлгүүд) Түүхийн ухааны д-р (Ph.D) зэрэг горилсон дисс. Э/ш-ний удирдагч проф. Шао Сюнь Чжан. Хамгаалсан 1962. Бээжин 1962. 270х

¹² Х.Пэрлээ Урьд мэдэгдээгүй гурван бичмэл УБ.,1957; Монголын хувьсгалын өмнөх түүх бичлэгийн асуудал.УБ.,1957;Дөчин дөрвөн хоёрын их цааз.Хөрвүүлэг УБ.,1959; Дондогдаш хааны үеийн Ижил мөрний халимагуудын зохиосон шашин төрийн зарчим. Хөрвүүлэг. УБ.,1959;Галдан хун тайжийн захиа зарлиг.Хөрвүүлэг. УБ.,1959. Шар туужийн зохиогчийн тухай.Түүхийн судлал. УБ.,1970; Монголын түүхийн тухай тэмдэглэлүүд. УБ.,1971; Халхын шинэ олдсон хууль эрхэмжийн дурсгалт бичиг.УБ.,1973

¹³ Ш.Нацагдорж Алтан товчийн зохиогчийн тухай. Шинжлэх ухааны Мэдээ. 1958.№3; Халхын Цогт хунтайжийн холбогдолтой нэгэн сурвалж бичгийн тухай. Монгол судлал.Т.VII.УБ.,1980; Улаан хацарт УБ.,1960; Дөрвөн амйгийн алба тэгштгэсэн данс (Ц.Насанбалжирын хамт) УБ.,1962; Ардын заргын бичиг. (Ц.Насанбалжирын хамт) УБ.,1968; Харьяат хошууны дотор дагаж явуулахаар тогтоон тушаасан ухуулах бичгийн эх. УБ., 1960

¹⁴ Ш.Бира Анализ основных данных “Белой истории” и время ее составления. Түүхийн судлал.Т.VIII.УБ.,1970; Хутугтай цэцэн хунтайжийн зохиосон нэгэн хуулийн тухай.ШУА-ийн мэдээ.1970.№3; XVI зууны нэгэн Монгол цаазны бичиг. ШУА-ийн мэдээ.1975, №3;

¹⁵ Н.Алтанцэцэг. Освещение истории антиманьчурской национально-освободительной борьбы монгольского народа в историографии КНР. Дисс. канд. Ист. наук (Ph.D)07.00.04. Науч.рук. д-р ист. наук. В.Н. Никифоров. М.,1986; Ц.Ишдорж.Зарождение и становление современной монгольской историографии 1921-1940гг. Дисс.канд. Ист. наук. (Ph.D): 07.00.09. Науч.рук.акад Ш.Бира. М., 1986;Д.Батбаяр. Современная историография руководства МНРП переходом народно-Монголии к социализму, минуя капитализм /с учетом опыта КПСС/ Дисс.канд.ист.наук (Ph.D) 07.00.01. Науч. Рук. Д-р. Ист.наук. проф.Г.В.Петряков. М.,1989; Ж.Баясах. Записки южносунских дипломатов как историко-этнографический источник по истории и этнографии Монголы XIII века.Дисс.канд.ист.наук.(Ph.D) 05.03.11.00. Научный рук д-р. Филол. Наук д-р. проф Чой.Лувсанжав /Монг гос унив Кафедра иностранных языков/ УБ.,1989

хуваан, хувьсгал ялснаар монголын үндэсний түүх бичлэгийн хөгжилд цоо шинэ үе эхэлсэн хэмээн дүгнэсэн байна.

Марксист түүх бичлэгийн үед түүх бичлэгийн судалгааны олон арван өгүүлэл хэвлэгдэн гарч монголын түүхийн шинжлэх ухааны хүрсэн түвшин шинж байдлын тухай илтгэж цаашид юу хийхийг чиглүүж байв. Энэ чиглэлээр түүхч Ш.Бира “БНМАУ-д түүх бичлэгийг хэрхэн судалж байгаа тухай”, “Монголын хуучны түүх бичлэгийн зарим нэг асуудал”, Ш.Нацагдоржийн “Манай түүхийн шинжлэх ухааны зарим ололт” /Үнэн сонин.1959.№276/, “Ардын хувьсгалын феодалыг эсэргүүцсэн шатны түүхийн зарим асуудал” /”ШУА-ийн мэдээ” 1967.№3/, “Манай түүхчдийн ажил үйлс, зорилт” /ШУА. Сэтгүүл.1976.№4/, Н.Сэр-Оджав “БНМАУ-д явуулсан археологийн шинжилгээний тухай” /А.П.Окладниковын хамт, ШУАМ. УБ., 1961. №2/, “40 жилд БНМАУ-д хийсэн эртний судлалын шинжилгээ” /SA,t.II.fasc.2.УБ.,1963/, Монголын төв умард хэсгийг археологийн талаар судлан шинжилсэн нь /SA,m.IV.fasc.7, УБ.,1965/ “Монголын археологчид” /ШУАМ.1968.№2/, Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалыг судалсан нь” /SH.t.VIII.Fasc.1-2,УБ.,1970/,Д.Наваан. Эртний судлал. /ШУА 1971.№1/, Б.Ширэндэвийн “БНМАУ-ын ШУА-иас өнгөрсөн таван жилд явуулсан шинжлэл судлалын ажлын үр дүн ба 1976-1980 онуудад гүйцэтгэх зорилт”, Н.Сэр-Оджав. Археологическая наука в МНР. /Олон улсын монголч эрдэмтний II их хурал. Боть II.УБ., 1973/, Д.Дорж “БНМАУ-ын нэн эртний түүхийн зарим асуудал” /ШУАМ.УБ.,1975.№4/, Дорж Д. “Манай түүхчид олон улсын монголч эрдэмтний хоёр их хурлын хооронд” ШУАМ, №2.УБ.,1987. “БНМАУ-ын түүхийн салбарт 1980-1985 онд явуулж буй судалгааны гол үр дүн, цаашдын зорилт. /ШУАМ.№3.УБ.,1985/, Монголын чулуун зэвсгийн судалгаа./ мөн тэнд, Деревянко А.П. хамт/, Р.Сугарсүрэн “Халхын голын байлдааны түүхийг судалж байгаа нь”, “Халхын голын байлдаанд оролцогсдын баатарлаг үйлсийг судалж сурталчлах”, Б. Цэдэв “МАН –ийн түүх бичлэгийн зарим асуудал”, Гомбосүрэн Д, Даваасүрэн Б. “Цэргийн түүх бичлэгийг судлах асуудалд”, Ч.Дашдаваа, Ц.Ишдорж нарын “Халх голын байдлааны түүх бичлэг”, Б.Баяраа “Монгол Зөвлөлтийн харилцааны түүхийг судалсан асуудалд”, Д.Батбаяр “Монголын түүхийн шинжлэх ухааны арга зүй хөгжлийн зарим асуудал” Н.Хишигт “Отечественная историография истории Монгольской Народной революции”, Б.Чинчулуун “БНМАУ-ын ажилчин ангийн түүх судалгааны байдал” зэрэг судалгааны ¹⁶ өгүүллүүд хэвлэгдэн гарсан байна.

Түүхч З.Лонжидийн “Монгол ардын хувьсгалт намын түүх бичлэгийн тойм” хэмээх товхимол хэвлэгдэн гарч¹⁷, намын түүхийг судлан боловсруулах, сурталчлах зорилгоор туурвисан намын түүх, нам, төрийн буюу иргэний түүхийг хамруулан бичсэн ном, өгүүлэл, дуртгал, нам төрийн зүтгэлтнүүдийн хэлсэн үг, илтгэл, их бага хурлын эмхтгэл материалууд зэрэг өргөн хэмжээнд хамруулан судлагдхуун болгон үзсэн байна.

Марксист буюу хөгжлийн хоёр дахь үеийн түүх бичлэгийн оргил нь Х.Пэрлээгийн “Монголын хувьсгалын өмнөх түүх бичлэгийн асуудалд”, Ш.Бирагийн “Опыт историографического исследования “Сэрги дептэра” Дамдина /К вопросу об изучении

¹⁶ Ш.Бира “БНМАУ-д түүх бичлэгийг хэрхэн судалж байгаа тухай” Түүхийн судлал. XV.Fasv 1-126 УБ.,1980; Р. Сугарсүрэн “Халхын голын байлдааны түүхийг судалж байгаа нь” ШУА.№4.УБ.,1984; Гомбосүрэн Д, Даваасүрэн Б. Цэргийн түүх бичлэгийг судлах асуудалд. -“Ардын арми” 1985.№2

Ч.Дашдаваа, Ц.Ишдорж Хал голын байлдааны түүх бичлэгийн асуудалд. Түүхийн судлал. XV. УБ.,1980; Б. Цэдэв “МАН –ийн түүх бичлэгийн зарим асуудал” ЭШБХ.УБ.,1981; Б.Баяраа. Монгол Зөвлөлтийн харилцааны түүхийг судалсан асуудалд. МАХН-ын түүх нийгмийн ухааны асуудал.ЭШ өгүүллийн эмхтгэл.УБ.,1987; Маму А., Сумъяа Б. К вопросу историографии Монгольской народной революции. Олон улсын Монголч эрдэмтдийн III их хурал. УБ.,1978. II боть.Д.Батбаяр. Монголын түүхийн шинжлэх ухааны арга зүй, хөгжлийн зарим асуудал. Түүхийн судлал XVIII.F.1-13.УБ.,1984, Н.Хишигт. Отечественная историография истории Монгольской Народной революции.Түүхийн судлал. XXI.1-10 дэвтэр. УБ.,1987, Б.Чинчулуун “БНМАУ-ын ажилчин ангийн түүх судалгааны байдал”.Түүхийн судлал.Боть. XXIV.УБ.,1990.

¹⁷ З.Лонжид Монгол ардын хувьсгалт намын түүх бичлэгийн тойм.УБ.,1980

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

монгольской тибетскоязычной исторической литературы/, “Монгольская историография (XIII-XVII вв)” зэрэг бүтээлүүд юм.

Судлаач Х.Пэрлээ бүтээлдээ Монголчуудын түүхийн мэдлэгийн хөгжлийг үечлэн хувааж, үе тус бүрийн сурвалжийн бичигдсэн онцлог, түүх зохиох арга ухаан, бичлэгийн хэлбэрийг нарийвчлан шинжилж, монголчууд эх түүхээ тасралтгүй зохиож хойч үедээ уламжлуулж ирснийг тодруулжээ. Тэрээр монголчуудын түүхийн зохиолд хэрэглэгддэг гол үг, хэллэг, утгыг хөөн судлаж, чимэг үсгийн жагсаалт болон хувьсгалын өмнөх монголчуудын түүхийн зохиолуудыг зохиогч болон зохиогдсон он цаг, анх хаанаас олдсон, хаана буй талаар товч боловч мэдээлсэн жагсаалтыг хийсэн нь монголын түүхийн судлалд эрж хайх сураг гаргахад тун дөхөмийг үзүүлжээ.

Академич Ш.Бира түүх бичлэгийн салбар ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтдийн нэг юм. Тэрээр монголчуудын түүхийн мэдлэг, түүх бичих ухааны хөгжлийн зүй тогтолыг тодруулан уламжлал шинэчлэлийн уялдаа холбоог нарийн гарган тавьсан байна. Тухайлбал түвд хэл дээр бичигдсэн зохиолуудыг судлан /Дамдины “Алтан дэвтэр”/ түүхийн талаар үнэтэй баримт мэдээ буйг гаргахын хамт монголчуудын түүх бичих уламжлалд түвдийн түүх бичих арга, буддийн шашны үзэл орж ирсэн боловч, монголчуудын түүхээ бичих үндсэн чиг шугам хэвээр байсныг гарган тавьжээ. Тухайлбал тэрээр Дамдины “Алтан дэвтэр” зохиолыг нарийвчлан судлаад хуучны түүх судлалын зохиолуудаас нэлээд өөрөөр буюу Монголын хаадын гарлыг манай орны нутагт оршин байсан эртний аймгуудын түүхээс эхлэн бичсэн болохыг тэмдэглэж, шашны түүхийг урьдах үеэс нэлээд өөрөөр тайлбарлах гэж оролдож байсныг тун гярхай гарган үзүүлснээрээ монголын түүх бичлэгийн сэтгэлгээний хөгжлийн зүй тогтолыг тодруулахад үнэтэй хувь нэмрээ оруулсан юм. Тэрээр дан ганц Дамдины “Алтан дэвтэр”-ээр зогсохгүй монголын хуучны түүх бичлэгийн “Цагаан түүх”, “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл”, “Шэн-у Цинь-чжэн-лу” зэрэг олон арван бүтээлийг судалсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

1990 оноос монголын нийгмийн зохион байгуулалт өөрчлөгдөж түүх бичлэг дэх арга зүйн баримтлал солигдон түүхэн уламжлалыг сэргээж, шинийг эрэлхийлэх болсон нь Монголын түүх бичлэгийн судалгаанд хөгжлийн шинэ шатыг авчирчээ. Түүхч, судлаачид түүхээ үнэн мөнөөр бичих, үзэл суртлын хальс бүрхэвчнээс ялган салгаж ойлгох эрмэлзлэлтэй хамт түүх бичлэгийн судалгаа хөгжиж байна.

Монголын түүхийг түүх шинэчлэлийн үүднээс нэгтгэн дүгнэхийг хичээсэн “ХХ зууны Монгол”/1994/, “Монголын улс төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил” I-II боть /1995/, “Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн, түүний хувь заяа” /2005/ зэрэг асуудал дэвшүүлсэн, сонирхол татахуйц хамтын бүтээлүүд нь түүх бичлэгийн судалгаанд шинэлэг уур амьсгалыг оруулж улмаар олон арван судалгааны бүтээлүүд цаашид төрөн гарах үүд хаалгыг нээжээ.

Эх түүхээ судлан боловсруулах түүх судлаачдын хүчийг зохион байгуулах, нэгтгэн зангидах түүхийн судалгааны байгууллагууд боловсон хүчин, баазын суурийн хувьд бэхжин, шинээр үүсч судлагдхууны цар хүрээ өргөсхийн хамтаар нарийсан гүнзгийрч буй нь ч монголын түүх бичлэгийн хөгжилд эерэг нөлөөг үзүүлж буй билээ.

ШУА-ийн Түүхийн хүрээлэн бүтцийн хувьд “Түүх бичлэг, эртний түүх, сурвалж судлалын салбар”, “Монголын эзэнт гүрний түүхийн салбар”, “Манжийн үеийн Монголын түүхийн салбар”, “Шинэ үеийн Монголын түүхийн салбар”, “Нийгэм, соёлын антропологийн салбар”, “Түүхийн баримтын сангийн салбар” гэсэн үндсэн зургаан салбарт Монгол улсын түүхийг үе тус бүрээр судалсны үр дүнд сүүлийн жилүүдэд /2005 оноос хойш/ тус хүрээлэнгээс эрхлэн “Монголын Алтан ордны улс” /2006/, “Монголын Юань улс”/2006/, “Монголын Цагаадайн улс” /2006/, “Монголын Эл хаант улс”/2006/, “Их Монгол улс”/2006/, “Эртний ба дундад Монголчуудын аж ахуй соёл” /2006/, “Монголын 1911 оны Үндэсний хувьсгал”,/2006/, “Манжийн үеийн Ар Монголын хилийн харуул”/2006/, “Монгол орны талаарх хөгжлийн үзэл баримтлал: хувьсал, өөрчлөлт”/2008/, “Олноо өргөгдсөн Монгол улсын гадаад харилц”/2008/, “Монгол дахь төрийн эргэлт”/2008/, “Халх Манжийн улс төрийн харилцаа”/2008/ зэрэг нэгэн сэдэвт суурь судалгааны бүтээлүүдийг хэвлэн нийтлүүлсэн байна.

Түүхийн хүрээлэн Монголын түүхч судлаачдын хүчийг нэгтгэн зангидах, монголын түүхийн судалгааны чиглэл, зорилго, зорилтыг тодорхойлоход оройлон оролцож түүхийн судалгаа, сургалтыг явуулж буй МУИС-ийн Түүхийн судалгааны хүрээлэн, Монголын түүхийн тэнхим, МУБИС-ын ТНУС-ийн Монголын түүхийн тэнхим, БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төв, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчлэн хийдийн дэргэдэх “Эрдэм соёлын хүрээлэн”-гийн эрдэмтэн судлаач, багш нартай санал солилцон зохион байгуулж ирлээ.

Монголын түүхийг шинжлэх ухааны үүднээс, учиг баримтыг ургуулан бодож, нотолгоо гаргалгаа хийж нягтлан судлаж, нууцад нэвтрэн орох гол түлхүүрийн нэг нь тухайн асуудлаарх судалгааны бүтээлүүдийг судлагдхуун болгон тавьж чухам юуг ямар онол арга зүйн үүднээс хэрхэн судалсан, цаашид юунд анхаарал хандуулахыг тодруулж өгдөг түүх бичлэгийн судалгаанд түүхийн судалгаа явуулж буй эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиуд анхаарлаа хандуулан үндэсний буюу олон хэмжээний эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулж байна¹⁸.

МУИС-ийн Түүхийн судалгааны хүрээлэнгээс эрхлэн зохион “ХХ зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэгийн зарим асуудал” сэдвээр 2005 онд, ШУА-ийн Түүхийн хүрээлэн “1911 оны Үндэсний хувьсгалын түүх бичлэг” сэдвээр 2007 онд эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, монголын түүх бичлэгийн тулгамдсан асуудал, хүрсэн түвшин, чиг хандлагыг тодорхойлсон олон арван дорвитой илтгэлүүдийг хэлэлцүүлэн хурлын материалыг нийтүүлжээ.

Монголын түүх бичлэгийн судалгааг урагш ахиулсан нилээд бүтээлүүд хэвлэгдэн гарсан байна. Үүнд: Ж.Болдбаатар “Монгол улсын түүх бичлэг: шинэчлэл, чиг хандлага (1990-ээд оноос эдүгээ хүртэл)” /2008/, “ХХ зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэгийн зарим асуудал” /2005/, Ш.Бира “Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа” /2001/, Б.Пунсалдулам “1911 оны Монголын Үндэсний хувьсгалын түүх бичлэг (1911-2003)” /2006/, Б.Пунсалдулам, Н.Хишигт “Монголын 1911,1921 оны хувьсгал (Гадаадын түүх бичлэгийн тойм)” /2007/, Д.Баярсайхан “XVII зууны монголын түүх бичлэг” /2006/, Т.Мөнхцэцэг “Япон дахь Монголын түүхийн судалгаа (1900-1995)” /2000/ зэргийг дурдаж болно. Үүнээс хамгийн дорвитой нь академич Ш.Бира, Ж.Болдбаатар нарын бүтээлүүд юм. Дээрх бүтээлүүдэд монголын түүх бичлэгийн хөгжлийн түүхийг түүхийн судалгааны байгууллагууд, монголын түүхийн үндсэн үеүүдийн судалгааны байдал, монголын түүхийн салбар болон хавсрага ухааны хөгжил, түүх бичлэгийн арга зүй, монголын түүхийн зарим нэг сэдэв, үеэр түүх бичлэгийн судалгаа хийж тодорхой амжитлтанд хүрчээ. МУИС-ийн Түүхийн судалгааны хүрээлэнгээс эрхлэн “ХХ зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэг” төслийг хэрэгжүүлж байна. Тухайлсан асуудлаар судалгаа хийж буй эрдэмтэн судлаачид судалгааны бүтээлүүдийг судлагдхуун болгон тавьж, эрдэм шинжилгээний өгүүллүүдийг өргөнөөр нийтлүүлж байна. Үүнд: Б.Батчулуун, Ж.Болдбаатар, Л.Мөнх-Эрдэнэ, Д.Мөнх-Очир, З.Лонжид, Ч.Дашдаваа, Б.Пунсалдулам, Н.Хишигт, Г.Мягмарсамбуу, С.Ганболд, С.Даваасүрэн, Х.Шагдар зэрэг олон судлаачдын өгүүллийг нэрлэж болно¹⁹.

¹⁸ Түүхийн судалгааны онол арга зүйн асуудал. УБ.,1999, Түүхийн танин мэдэхүйн явц дахь мета онолын ба эмпирик асуудлууд- Орчин үе.УБ.,2004, Түүхийн хавсарга ухаан. УБ.,2004, Төр сүм хийдийн харилцаа: орчин үе.УБ.,1998, Түүхийн судалгаа, сургалт арга зүйн тулгамдсан асуудлууд. УБ.,2001, Монголын түүхийн сурвалж судлал: Өнөөгийн байдал, судалгааны асуудлууд. УБ.,2004, Цэргийн эрдэм судлал 40 жил.УБ.,1999, Цэргийн түүх судлалын төв: Бүтээлийн товчоон.УБ.,2003, Цэргийн шинжлэх ухааны тулгамдсан асуудлууд. ЭШБХ. УБ.,2003, Цэргийн түүх судлалын төв: Бүтээлийн товчоон.УБ.,2009

¹⁹ Батчулуун Б. Түүх бичлэгийн онолын зарим асуудал. ХХ зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэгийн зарим асуудал. УБ.,2005 Болдбаатар Ж. Монголын түүхийн судалгаа-сургалтын онол-арга зүйн өнөөгийн төлөв байдал, цаашдын хандлага. Түүхийн судалгааны онол арга зүйн асуудал.УБ.,1999 Болдбаатар Ж., Батбаяр Д. Монголын түүх бичлэгийн тулгамдсан асуудлууд. ХХ зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэгийн зарим асуудал. УБ.,2005, Болдбаатар Ж., Мөнх-Эрдэнэ Л. Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхийг судлах онол-арга зүйн зарим хандлага. Манжийн эрхшээлийн үеийн Монгол.

III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

Мөн өгүүлэн буй үеэс монголын түүхийн судалгааны онол арга зүйн сэтгэлгээний хөгжилд гарсан өөрчлөлтийг түүхийн гүн ухааны үүднээс авч судлахыг зорьсон Ж. Болдбаатар, Д.Батбаяр, Л.Мөнх-Эрдэнэ нарын “Монголын түүхийн судалгаа-сургалтын онол-арга зүйн өнөөгийн төлөв байдал, цаашдын хандлага” /Түүхий судалгааны онол арга зүйн асуудал.УБ.,1999/ “Монголын түүх бичлэгийн тулгамдсан асуудлууд” /XX зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэгийн зарим асуудал. УБ.,2005/,”Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхийг судлах онол-арга зүйн зарим хандлага. /Манжийн эрхшээлийн үеийн Монгол. УБ.,2004/ зэрэг өгүүллийг нэрлэж болно. Гэсэн хэдий ч 1990 оноос хойшх түүх бичлэгийн судалгаа гэхээсээ судалгааны тойм төдийгөөр хязгаарлагдаж буйг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна. Үүнд түүхийн судалгааны онол- арга зүйн зарчим, баримтлалууд үүсэн бүрэлдэх шатандаа явж байгаа тул түүх шинэчлэлийн үйл явц удаашралтай байгаа нь нөлөөлж байна.

УБ.,2004, Лонжид З. Богд хаантан ба Монголын түүх бичлэг. XX зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэгийн зарим асуудал. УБ.,2005 Т.Намнансүрэнгийн намтар судлалын хураангуй тойм. “Богд хаант Монгол улсын анхны ерөнхий сайд сайн ноён хан Т.Намнансүрэн” УБ., 1998, XX зууны Монголын түүхэн хүмүүсийн намтар судлалын тойм. “XX зууны Монголын түүхийн зарим асуулалд”/эмхтгэл/. 1999, Цэрэнчимэд ба Монголын түүх бичлэг. “Да лам Цэрэнчимэд” эмхтгэл. УБ., 2002, Манжийн үеийн Монголын түүхийн нэгэн чухал сурвалж. Манжийн эрхшээлийн үеийн Монгол. УБ.,2004, Пунсалдулам Б. 1911 оны Үндэсний хувьсгалын удирдагчдын түүх бичлэгийн асуудалд. МУИС-ийн ЭШБ. №188/14/“Түүх-II”. УБ., 2002, Монголын цагаагчин гахай жилийн хувьсгал “Шинэ толь” сэтгүүл. УБ., 2002. №39, Түүх бичлэгийн шинэчлэлийн асуудалд “Шинэ толь” сэтгүүл. УБ., 2003. №44, 1911 оны үндэсний хувьсгалын түүх бичлэгийн үечлэл, ангилалын асуудалд. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. “Түүх” сэтгүүл. № 190. УБ., 2004,XX зууны эхэн үеийн Монголын түүх бичлэгийн тойм, онцлог. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. “Түүх” сэтгүүл.2006, Монголын дундад үеийн төр эрх зүйн түүхийн судалгаа. “Түүхийн судлал”боть XXXVII.УБ.,2007 ,1755-1758 оны монголчуудын зэвсэгт тэмцлийн түүх бичлэг.Монголчуудын Манжийн эсрэг 1755-1758 оны тэмцэл. УБ.,2007, Оросын түүх судлал дахь Монголын үндэсний хувьсгалын тухайд. “Монголын үндэсний хувьсгал-95” эрдэм шинжилгээний хурлын материал. УБ.,2007, Российско-Монгольская историография истории Улан-Баторской железной дороги. Императивы Юссии в транспортную систему восточной Азии. Улан-Удэ.,2008 / Курас Л.В. хамт/, Хишигт Н. Халхын голын дайныг олон ургальч үзлээр үнэлж байгаа нь. Тусгаар тогтнол. 1994.IX.1-10. № 25, 1921 оны хувьсгалын түүхэнд Д.Сүхбаатарын эзлэх байр суурь: 1990-ээд оноос хойшхи түүх бичлэгийн асуудалд. Түүхийн судлал. Том XXXIV. Fasc.15.УБ., 2003, 1921 оны хувьсгалын түүх бичлэгийн асуудалд (1920-1930-аад он)”-// “ШУА-ийн мэдээ”.УБ., 2006.№ 3 (181), Д.Бодоогийн амьдрал үйл ажиллагаа Монголын түүх бичлэгт” Д.Бодоогийн мэндэлсэний 120 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Зуун мод хот. 2006, Монгол Оросын орчин үеийн түүх бичлэгт Халхын голын дайны асуудал тусгагдсан нь. Халхын голын дайны ялалтын 65 жилийн ойд зориулсан олон улсын симпозиум. БХЭШХ. Эрдэм шинжилгээний бага хурлуудын эмхтгэл. 2. УБ., 2006. Халхын голын дайны түүхийн судалгаа ба эрдэмтдийн хамтын ажиллагаа. Япон судлал. №1.УБ., 2007,Дэлхийн хоёрдугаар дайны үеийн Монголын түүхийн судалгааны асуудалд. Монголын нэрт түүхч, академич Ш.Нацагдоржийн мэндэлсэний 90 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар.2008.09.12

К вопросу о периодизации историографии Монголии

Основанная на летописных традициях, историческая наука в Монголии сформировалась в современном ее понимании в XX в. В новую эпоху начали отказаться от традиционного подхода к своей истории, ограниченного историями царей и религии и активно освоить и использовать современный научный метод в исторических исследованиях и критически осмыслить.

Историческая наука Монголии за 120 лет развития, сталкивалась немалыми трудностями. За этот период было и время застоя, когда история рассматривалась в черно-белом свете. Тем не менее, не остановилось развитие науки, -непрерывно велись поиски разных интерпретации своей истории. Надо особо отметить, что ныне критикуемая марксистская историография служила важным фактором развития исторической науки в Монголии.

Началом развития историографической науки в Монголии можно считать 1920-гоном и по состоянию исследования разделить на периоды от 1920г - до 1957г., от 1957г - до 1990г., и после 1990 г. По мере развития исторической науки, одновременно развивалась и историографическая наука в Монголии.